



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 60

Есөнбулаг сум

Хувьчлах хөрөнгийн жагсаалтанд
өөрчлөлт оруулж, хөрөнгө данснаас хасах,
үнэ тогтоон худалдан борлуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 16-ны 35 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчөөс 2015 онд хувьчлах хөрөнгийн жагсаалтад хувьчлагдахаар батлагдсан Бигэр сумын Эрүүл мэндийн төвийн хуучин барилга, Бугат сумын Дунд сургуулийн автомашины гражийг тухайн оны хувьчлах хөрөнгийн жагсаалтаас хассугай.

2. Хувьчлах хөрөнгийн жагсаалтаас хасагдсан Бигэр сумын Эрүүл мэндийн төвийн хуучин барилгыг акталж хавсралтад тогтоосон үнээр худалдан борлуулахыг, Бугат сумын Дунд сургуулийн автомашины гражийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

3. Акталж данс бүртгэлээс хасч буй барилгыг тогтоосон үнээр худалдан борлуулж аймгийн Төрийн сангийн өмч хувьчлалын орлогын 050000961 тоот дансанд төвлөрүүлэн, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг холбогдох хууль, журмын дагуу хийж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /С. Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА

Т. ГАНЗОРИГ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны ...
 дугаар сарын ...-ний өдрийн ...-р тогтоолын
 хавсралт



Акталж, үнэ тогтоон худалдан борлуулах хөрөнгийн жагсаалт

Д/д	Эзэмшигч байгууллага	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоошир хэг	Анхны үнэ	Бүгд үнэ	Нийт элэгдэл	Үлдэх өртөг	ОНӨГ-аас худалдах үнийн санал	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас худалдан борлуулахаар тогтоосон үнэ
1	Бигэр сумын ЭМТ	Эрүүл мэндийн төвийн хуучин барилга	1962	ш	1	395,100,000	395,100,000	348,151,285	46,948,715	3,000,000	3,000,000
Нийт дүн					1	395,100,000	395,100,000	348,151,285	46,948,715	3,000,000	3,000,000